

	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн <i>108</i> тоот тушаалын зургаадугаар хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.20	Хуудасны тоо: 15
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан 		Танилцах албан тушаалтнууд: Багш нар	

“ОЮУТАН СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ЧАДАМЖИЙГ ҮНЭЛЖ, БАТАЛГААЖУУЛАХ” ЖУРАМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт




Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	Ерөнхий эрдэм хариуцсан Арга зүйч	Бадрах Аззаяа	2026.01.16	
Хянасан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2026.01.19	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.20	


НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ. Нийтлэг үндэслэл.....	1
ХОЁР. Журмын үйлчлэх хүрээ, үнэлгээний зарчим.....	1
ГУРАВ. Үнэлгээний төрөл, арга.....	2
ДӨРӨВ. Үнэлгээ, зохион байгуулалт, баталгаажуулалт.....	2-7
ТАВ. Үнэлгээний шалгуур.....	7-8
ЗУРГАА. Үнэлгээ, баталгаажуулалтад оролцогчийн чиг үүрэг.....	9-12
ДОЛОО. Үнэлгээ зохион байгуулах арга, хэлбэр.....	12
НАЙМ. Нотолгоог бүрдүүлэх аргачлал.....	12-13
ЁС. Хяналт хариуцлага.....	13
АРАВ. Санхүүжилт.....	13
АРВАН НЭГ. Санал гомдол шийдвэрлэх.....	14
АРВАН ХОЁР. Бусад.....	14
АРВАН ГУРАВ. Хамаарах баримт бичиг	14-15
АРВАН ДӨРӨВ. Маягт.....	15

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх, баталгаажуулах үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ.

1.2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/128 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам”-ын хэрэгжилтийг хангах.

1.3.Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол сургалт, техникийн боловсрол сургалт, богино хугацааны мэргэжил эзэмшүүлэх сургалт, байгууллагын захиалгат сургалт, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх болон бусад сургалтад хамрагдагчийн явцын болон төгсөлтийн үнэлгээг зохион байгуулахтай холбоотой асуудлууд энэхүү журмаар зохицуулагдана.

1.4.Байгууллагын сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, стандарт, чанарын үнэлгээнд нийцсэн сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр.Журмын үйлчлэх хүрээ, үнэлгээний зарчим

2.1.Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын суралцагч болон хөтөлбөрийг хангаж мэргэжил эзэмшсэн төгсөгч

2.2.Мэргэжлийн сургалтаар чадамж эзэмшихээр суралцаж буй болон эзэмшсэн иргэн

2.3.Албан бус сургалт, байгууллагын захиалгат сургалт, амьдрах орчны хүрээнд чадамж эзэмшихээр суралцаж буй болон эзэмшсэн иргэн

2.4.Үнэлүүлэгчийн мэдлэг, ур чадвар чадамжийг, дүгнэхэд дараах зарчмыг баримтална.


2.4.1.үнэлгээ тохирцтой, найдвартай, шударга, уян хатан байх;

2.4.2.баримт нотолгоонд тулгуурласан, бодитой байх;

2.4.3.үнэлгээ суралцагчийн ахиц амжилт, хүрсэн түвшин тодорхойлох, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.4.4.үнэлгээ нь суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан, тэгш боломжийг олгосон байх;

2.4.5.үнэлгээ нь суралцагчийн гүйцэтгэлийг бүрэн илэрхийлэх, гүйцэтгэлийн шалгуурыг хамарсан болон нотолгоонд тавих шаардлагыг хангасан байх;

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Гурав.Үнэлгээний төрөл, арга

3.1.Сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, ур чадвар, чадамжийн үнэлгээ дараах төрөлтэй байна.

3.1.1.“Оношлох үнэлгээ” гэж сургалтад хамрагдахын өмнө суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадварын суурь түвшнийг тодорхойлох үнэлгээ;

3.1.2.“Явцын үнэлгээ” гэж сургалтын явцад суралцагчийн сурах үйл ажиллагаа, эзэмшсэн чадамжид гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлох үнэлгээ;

3.1.3.“Чадамжийн нэгжийн үнэлгээ” гэж суралцагч сургалтын хөтөлбөрийн нэгж чадамжийг судалсны дараа хийгдэх, тухайн чадамжийн нэгж дэх мэдлэг, ур чадварын түвшнийг тогтоох үнэлгээ;

3.1.4.“Төгсөлтийн үнэлгээ” гэж тодорхой мэргэжлээр суралцаж төгсөх үед хийгдэх, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийн түвшнийг тогтоох, үр дүнд үндэслэн боловсролын баримт бичиг олгох үнэлгээ;

3.2.Сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн чадамжийн нэгжийн үнэлгээ нь онолын мэдлэгийн болон мэргэжлийн ажилбар, даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээ гэсэн хоёр хэсэгтэй байна.

3.3.Үнэлгээнд зорилго, төрөл, зохион байгуулалтаас шалтгаалан ажиглалт, ярилцлага, асуулт, сорил, судалгаа, бүтээлийн сан, гүйцэтгэлийн, эцсийн бүтээгдэхүүний аргуудаас сонгон ашиглана.

3.4.Хөгжлийн бэрхшээлтэй үнэлүүлэгчийг бэрхшээлийн онцлогоос хамаарч үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийг тусгайлан боловсруулж үнэлнэ.


3.5.Байгууллагын захиалгат богино хугацааны мэргэжлийн сургалтад явцын, чадамжийн нэгжийн, төгсөлтийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ.

3.6.Мэргэжлийн сургалтын үргэлжлэх хугацаа нь чадамжийн нэг буюу хэд хэдэн нэгжийг бүрэн эзэмшүүлбэл зохих хугацаагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ болж болно.

Дөрөв.Үнэлгээ зохион байгуулалт, баталгаажуулалт

Сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээг дараах байдлаар зохион байгуулна.

4.1.Оношлох үнэлгээг элсэгчийн мэдлэг, ур чадвар, чадамж, хандлагын давуу болон сул талыг тодорхойлох, суурь түвшнийг тогтоох, үр дүнд үндэслэн сургалтын төлөвлөлт хийх зорилготой ба суралцагч сургалтын байгууллагад элсэн суралцсанаас хойш нэг сарын дотор сургалтын алба зохион байгуулна.

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

4.2. Явцын үнэлгээний зохион байгуулалт

4.2.1. явцын үнэлгээг сургалтын явцад тухайн мэргэжлийн хөтөлбөр дэх чадамжийн нэгжийн эзэмшилт, ахицыг тодорхойлох, эзэмшиж чадаагүй мэдлэг, ур чадварыг илрүүлж, суралцагчдад дэмжлэг үзүүлэх зорилготой ба үнэлгээг тухайн мэргэжлийн хичээл заадаг багш зохион байгуулна;

4.2.2.а чадамжийн нэгжийн мэдлэг олгох агуулгын хүрээнд заагдах элемент бүрийн төгсгөлд явцын үнэлгээг багш зохион байгуулна;

4.2.2.б явцын үнэлгээний материалыг багш боловсруулж арга зүйчээр хянуулна;

4.2.2.в явцын үнэлгээний хуваарийг сургалтын албаны ажилтанд гарган өгч сургуулийн нэгдсэн явцын үнэлгээний график улирлын 3 дугаар долоо хоногт багтаан;

4.2.2. үнэлгээний комиссын гишүүдийг захирлын зөвлөлөөр хэлэлцэн ӨПК М-263-001 маягтаар гарган захирлын тушаалаар баталж, зохион байгуулна;

4.2.3. тухайн нэгж хичээлийн хөтөлбөрийн дагуу суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг 100%-р үнэлэх ба 70% нь явцын үнэлгээ болно;

4.2.4. багшийн зүгээс суралцагчийн мэдлэгийг дүгнэх явцын үнэлгээ 4 үндсэн хэсгээс бүрдэнэ. Энэ нь тухайн хичээлд тавигдах шаардлага, онцлогоос хамаарч харилцан адилгүй хувь хэмжээтэй байж болно; $E70=A1+A2+A3+A4$;

70 - Явцын үнэлгээний 70%-ийн дүн

A1 – Хичээлийн ирц 10

A2 – Онолын мэдлэгийн түвшин 20

A3 – Лаборатори, дадлага, семинарын хичээлийн даалгаврын биелэлт 20


A4 – Бие даан судлах даалгаврын биелэлт 20

4.2.5. ЧССХ-ийн нэгж бүрийн эцэст багш өөрийн хичээл заасан суралцагч бүрийн 70%-ийн үнэлгээг дүгнэж багшийн журнал, дэвтэрт засваргүйгээр тэмдэглэнэ.

4.2.6. суралцагчаас тест, бодлого, зураг тооцоо, дасгал жишээн дээр судлах даалгаврын хамгаалалт зэрэг явцын үнэлгээг хэзээ, хэдэн удаа, ямар аргаар дүгнэх талаар багш сургалтын албатай тохиролцож, суралцагчдад улирлын эхэнд урьдчилан тодорхой мэдэгдэнэ.

4.2.7. багш зааж буй хичээлдээ “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр” (ЧССХ)-ийн явцад суралцагчийн мэдлэгийг 3-аас доошгүй удаа, ур чадвар эзэмшилтийг даалгаврын ажилбар бүр дээр хянаж дүгнэсэн байх бөгөөд үүнийг тухай бүр суралцагчид ил тод мэдэгдэж байна.

4.2.8. чадамжийн нэгжийн үнэлгээний хуваарийг тэнхим хариуцсан арга зүйчтэй хамтран боловсруулж, арга зүйчээр хянуулж, Сургалтын албаны

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

менежер баталгаажуулалт хийж, үнэлгээ эхлэхээс нэг долоо хоногийн өмнө суралцагчдад мэдэгдсэн байна.

4.2.9.явцын үнэлгээний 70%-ийн дүнгээр 40%-с доош үнэлгээ авсан суралцагчийг чадамжийн нэгжийн үнэлгээнд оруулахгүй.

4.2.10.тестээр болон бичгээр авах тохиолдолд хичээлийн судалсан агуулгаас хамаарч хугацааг тодорхойлж байна. Үнэлгээг амаар авах тохиолдолд 1 цагт 6 оюутан байхаар зохион байгуулна.

4.3. Чадамжийн нэгжийн үнэлгээний зохион байгуулалт:

4.3.1.чадамжийн нэгжийн үнэлгээг сургалтын хөтөлбөрт тусгагдсан чадамжийн нэгж тус бүрийг судалж дууссаны дараа сургалтын алба, ажил олгогчийн төлөөлөл бүхий сондгой тооны гишүүдээс бүрдсэн үнэлгээний баг зохион байгуулах бөгөөд үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг сургалтын байгууллагын захирлын тушаалаар томилно;

4.3.а.чадамжийн нэгжийн үнэлгээг хийхдээ бүтээлийн сангийн, эцсийн бүтээгдэхүүний, гүйцэтгэлийн үнэлгээний аргыг түлхүү ашиглана;

4.3.б.суралцагчийн чадамжийн нэгжийн үнэлгээний дүнг сургалтын алба баталгаажуулан цахим мэдээллийн системд оруулна;

4.3.в.чадамжийн нэгжийн үнэлгээний үр дүнд дүн-шинжилгээ хийх, даалгаврын сан бүрдүүлэх ажлыг сургалтын алба, үнэлгээний баг хариуцан гүйцэтгэнэ;


4.3.2.тухайн чадамжийн нэгжийг судалж дууссаны дараа нэгжийн үнэлгээг зохион байгуулна. Чадамжийн нэгжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэлд тохирсон ажилбарын ажлын даалгавар болон онолын мэдлэг үнэлэх үнэлгээний материалыг мэргэжлийн багш боловсруулж, сургалтын менежер хянаж, баталгаажуулна;

4.3.3.чадамжийн нэгжийн үнэлгээнд "Хараахан чадамж эзэмшээгүй" (ХЧЭ) гэж үнэлэгдсэн сурагчдад агуулгыг бие даан нөхөж судлах боломж олгож, багш нар зөвлөн туслах төлөвлөгөөт хуваарийн дагуу сурагчдад дэмжлэг үзүүлнэ;

4.3.4.чадамжийн нэгжийн агуулгын хүрээнд давтан үнэлгээ хийлгэх суралцагч сургалтын албанд хүсэлт гаргаж, сургуулийн дансанд 10000 төгрөгийг тушааснаар давтан үнэлүүлэх боломжтой;

4.3.5.чадамжийн нэгжийн үнэлгээний онолын болон ур чадварын дүнг журналд гүйцэтгэлийн хувь, чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үнэлгээгээр тэмдэглэж, улирлын дүн гаргах суурь нөхцөлийг бүрдүүлнэ;

4.3.6. чадамжийн нэгжийн үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийн дагуу

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

үнэлгээнд шаардлагатай түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог тухайн мэргэжлийн багш хийж, сургалтын байгууллага үнэлгээний орчныг бүрдүүлнэ;

4.3.7.үнэлгээ эхлэх цаг, үнэлгээ хийх байр үнэлгээний хуваарийн хамт гаргасан байна;

4.3.8.Захирлын тушаалаар томилогдсон асент багш нар үнэлгээний явцыг удирдах, хянах үүрэгтэй ба ажлын хэсгүүд үнэлгээний протокол үйлдэн баталгаажуулж, холбогдох маргаантай асуудлыг шийдвэрлэнэ;

4.3.9.суралцагчийн үнэлгээний бэлтгэлийг анги удирдсан багш шаардлагын түвшинд хангуулна;

4.3.10.суралцагч тухайн хичээлээр тогтоосон хугацаанд үнэлүүлэх боломжгүй хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ тухай үнэлгээ эхлэхээс 3 хоногийн өмнө сургалтын албанд бичгээр өргөдөл гаргаж хугацааг хойшлуулах зөвшөөрөл авна;

4.3.11.үнэлгээний хугацаа дууссаны дараа суралцагчийн үнэлгээний материалыг хурааж, шалгагч багш материалыг засаж, дүнг “Үнэлгээний тогтоол”-д баталгаажуулж сургалтын албанд хүлээлгэн өгнө;

4.3.12.суралцагчийн үнэлгээний дүнг үнэлгээ авсан өдрөөс хойш 2 хоногийн дотор мэдээлж байна;


4.3.13.үнэлгээний цаг үл баримталсан, ёс зүйн зөрчил гаргасан, үнэлгээнд хуулах, бусдад дамжуулах, зөвшөөрөгдөөгүй материал ашигласан гэх зэргээр үнэлгээний дэг зөрчсөн суралцагчийг үнэлгээнд унасан тооцно;

4.3.14.үнэлгээний нэгдсэн хуваарь зөрчсөн, үнэлгээг зөвшөөрөлгүйгээр дахин авсан, үнэлгээний материал нууцлал, түлхүүрийг задалсан буюу буруу хийсэн, суралцагчийн үнэлгээний материал дээр нэр тавьсан, шифр дамжуулсан, цаг баримтлаагүй, үнэлгээний материал засварлан дүгнэсэн, баталгаажаагүй материалаар үнэлгээ авсан, үнэлгээг бүрэн бус бүрэлдэхүүнтэйгээр авсан зэрэг зөрчил гарсан багш, ажилтнуудад хөдөлмөрийн дотоод журамд заагдсан хариуцлага хүлээлгэнэ;

4.4.Төгсөлтийн үнэлгээг дараах байдлаар зохион байгуулна.

4.4.1.төгсөлтийн үнэлгээ нь суралцагч тухайн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардагдах суурь чадамжийг эзэмшсэн эсэхийг нотолгоонд суурилан илрүүлж, үр дүнд үндэслэн боловсролын баримт бичиг олгох бөгөөд сургалтын байгууллагаас томилсон үнэлгээний баг зохион байгуулна;

4.4.2.нотолгоо нь шууд (үнэлүүлэгчийн шууд гүйцэтгэл, асуултын хариулт гэх мэт), шууд бус (сорил, эцсийн бүтээгдэхүүн, төсөлт ажил,

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

гүйцэтгэлийн үеэр авсан зураг, бичлэг, гэх мэт) гэсэн хоёр төрөлтэй байна;

4.4.3.үнэлгээний баг мэргэжлийн багш, түншлэгч, ажил олгогчийн төлөөлөл, үнэлгээний ажилтнаас бүрдэх ба таваас доошгүй гишүүнтэй байна;

4.4.4.үнэлгээний ажилтан тухайн мэргэжлээр мэргэшсэн, таваас доошгүй жил ажилласан мэргэжлийн багш, дадлага туршлагатай инженер, техникийн ажилтан, мэргэжилтэн байх ба чадамжийн үнэлгээний сургалтад хамрагдсан байна;

4.4.5.төгсөлтийн үнэлгээ зохион байгуулахаас нэг сарын өмнө сургалтын байгууллагаас томилсон үнэлгээний баг үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад хүргүүлж, баталгаажуулна;

4.4.6.Үнэлгээний төлөвлөгөөнд баталгаажуулалт хийхэд дараах үндсэн шалгуурыг мөрдөнө. Үүнд:

4.4.6.а.үнэлгээний багийн бүрэлдэхүүн энэ журмын 4.4.3, 4.4.4-д заасны дагуу томилогдсон байх;

4.4.6.б.үнэлгээний зорилго нь ойлгомжтой, тодорхой, сонгосон арга хэрэгсэл нь зорилготойгоо нийцтэй байх;

4.4.6.в.үнэлэх чадамжууд нь тухайн мэргэжлийн ажил мэргэжлийн стандарт болон сургалтын хөтөлбөртэй нийцсэн байх;

4.4.6.г.үнэлгээний даалгавар нь ажлын байрны тодорхой нөхцөлд ямар нэг бодитоор тулгардаг асуудлыг шийдвэрлэх шинж чанартай байх, мөн хугацаа нь бодитой байх;

4.4.6.д.үнэлгээний орчин болон шаардлагатай хэрэглэгдэхүүн, багаж төхөөрөмж, түүхий эд материалын жагсаалтыг харуулсан байх;


4.4.6.е.үнэлгээнд ялгаатай хэрэгцээтэй төгсөгч хамрагдахаар бол түүний онцлогт тохирсон үнэлгээний арга хэрэгслийг сонгосон байх;

4.4.6.ё.гүйцэтгэлийн үнэлгээний ажиглалтын хуудсыг бэлтгэсэн байх, ажиглалт хийх шалгуур үзүүлэлтүүд нь хэмжигдэхүйц байх;

4.4.6.ж.суралцагчийн гүйцэтгэлээс шалтгаалан нэмэлтээр асуух асуултыг төлөвлөсөн, түүнийг хэрхэн үнэлж дүгнэх аргачлал тусгагдсан байх;

4.4.7.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаас томилсон баг сургалтын байгууллага болон мэргэжлийн чиглэлийг түүвэрлэн баталгаажуулалт хийнэ. Баталгаажуулалтыг чадамжийн үнэлгээний явцад эсвэл дараа нь хийнэ;

4.4.8.чадамжийн үнэлгээний баталгаажуулалтыг Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын мэргэжилтнүүд болон тухайн мэргэжлийн


 ВМНОГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
--	---	---

6.4. Сургалтын байгууллагын чиг үүрэг:

- 6.4.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан анги, танхим, дадлагын газар, тоног төхөөрөмж бүхий үнэлгээний орчныг бүрдүүлсэн байх;
- 6.4.2. ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн үнэлгээний орчныг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;
- 6.4.3. үнэлгээ зохион байгуулах эрх олгосон гэрчилгээтэй байх;
- 3.4.4. Үнэлгээний болон баталгаажуулалтын ажилтантай байх;
- 6.4.5. үнэлгээний баг томилох;
- 6.4.6. чадамжийн нэгжийн үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, батлах;
- 6.4.7. үнэлгээний багийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 6.4.8. сургалтын явцад ахиц дэвшлийн үнэлгээг зохион байгуулах,
- 6.4.9. төгсөлтийн үнэлгээг зохион байгуулах, дүн мэдээг нэгтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх;
- 6.4.10. үнэлгээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж баталгаажуулан оролцогч талуудад мэдээллийг бүрэн хүргэх;
- 6.4.11. тодорхой үндэслэл, шалтгаанаар үнэлгээний төлөвлөгөөг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлөлт хийж, зарлан мэдэгдэх;
- 6.4.12. үнэлгээтэй холбогдон гарсан аливаа санал, гомдлыг шийдвэрлэх;
- 6.4.13. суралцагчийг тодорхой шалтгааны улмаас үнэлгээнд оруулахгүй байх, үнэлгээнээс чөлөөлөх, үнэлгээнд орох эрхийг сэргээх, дахин буюу давтан үнэлгээг зохион байгуулах;
- 6.4.14. үнэлгээг шууд хариуцан зохион байгуулах, явцад нь хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, анализ дүгнэлт хийж түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллах;

6.5. Үнэлгээний ажилтны чиг үүрэг:

- 6.5.1. үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах;
- 6.5.2. үнэлгээний орчинтой танилцаж, заавар зөвлөмж өгөх, үнэлгээний орчныг бүрдүүлэх;
- 6.5.3. үнэлгээний орчин, удирдамжийг үнэлүүлэгчид танилцуулах, зөвлөмж өгөх;
- 6.5.4. үнэлүүлэгчийн эрх, үүргийг танилцуулах;
- 6.5.5. үнэлгээний зохион байгуулалт, явцын талаар баталгаажуулагчид санал гаргах;
- 6.5.6. үнэлүүлэгчид үнэлгээний үр дүнг танилцуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 6.5.7. үнэлгээний тайлан, нотлох баримтыг бүрдүүлж, Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад хүлээлгэн өгөх;


	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

- чиглэлийн ажил олгогчийн төлөөллөөс бүрдсэн баг хийх ба урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу баталгаажуулна;
- 4.4.9. баталгаажуулалтын багийн гишүүн чадамжийн үнэлгээ, баталгаажуулалтын сургалтад хамрагдсан байна;
- 4.4.10. баталгаажуулалтыг дараах үндсэн шалгуурын дагуу хийнэ;
- 4.4.10.а. үнэлгээний орчны тохирц, аюулгүй байдал, эрүүл ахуй;
 - 4.4.10.б. үнэлгээний даалгавар, шалгуур, арга, хэрэгслийн тохирцтой болон хэрэгжих боломжтой байдал;
 - 4.4.10.в. үнэлгээний шийдвэрийн найдвартай, шударга байдал;
 - 4.4.10.г. сургалтын байгууллагын зохион байгуулсан чадамжийн нэгжийн үнэлгээний үр дүн;
- 4.4.11. үнэлүүлэгчийн мэргэшлийн түвшин бүрд харгалзах чадамжийн нэгжийн үнэлгээ нь онолын болон ур чадварын хэсгээс бүрдэнэ. Онолын мэдлэгийг амаар болон бичгээр, ур чадварыг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу ажилбар гүйцэтгүүлж үнэлнэ;
- 4.4.12. мэргэшлийн онцлогоос шалтгаалан I, II түвшинд онолын мэдлэгийг үнэлэхгүй байж болно;
- 4.4.13. МБСҮТ-ийн даргын 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/58 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээний багц төлөвлөгөө”-ний загварын дагуу үнэлгээний багц төлөвлөгөөг боловсруулан ҮМАЗТ-өөр батлуулан үнэлгээнд ашиглана;
- 4.4.14. Сургалтын менежер, үнэлгээний баг материалыг хүлээлцэх, задлах хувилах, үнэлгээний дүнг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна;
- 4.4.15. үнэлгээний баг төгсөлтийн үнэлгээний явц, давуу болон сул тал, цаашид анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргана;
- 4.4.16. мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд бүх чадамжийн нэгжийг эзэмшиж, “Чадамжтай” гэж үнэлэгдсэн тохиолдолд төгсөлтийн үнэлгээнд орох эрхтэй;

Тав. Үнэлгээний шалгуур

5.1. Суралцагч, төгсөгчийг үнэлж, дүгнэх шалгуурыг мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн чадамжийн нэгж, элемент тус бүрийн хүрээнд боловсруулж, энэхүү журмын 3.3-д заасан үнэлгээний аргад нийцүүлнэ.

5.2. Бүрэн дунд боловсролын үнэлгээг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д заасан журмаар зохицуулна.

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Хувьчилсан оноо	Тоогоор илэрхийлсэн үнэлгээ
90-100	VIII
80-89	VII
70-79	VI
60-69	V
50-59	IV
40-49	III
30-39	II
0-29	I

5.3. Мэргэжлийн боловсролын үнэлгээг “Чадамжтай (Ч)”, “Хараахан чадамж эзэмшээгүй (ХЧЭ)” гэж үнэлнэ. Онолын үнэлгээний гүйцэтгэл 70 хувь ба түүнээс дээш, ур чадварын гүйцэтгэл 85 хувь ба түүнээс дээш үнэлэгдсэн бол “Чадамжтай”, түүнээс доош бол “Хараахан чадамж эзэмшээгүй” гэж үнэлнэ.


5.4. Монгол ур чадвар, Дэлхийн ур чадварын уралдаан, тэмцээнд оролцож шагналт болон тусгай байр эзэлсэн суралцагчийн төгсөлтийн үнэлгээний гүйцэтгэлийг 100 хувиар тооцож, төгсөлтийн үнэлгээнээс чөлөөлж болно.

5.5. Техникийн боловсролын үнэлгээг дараах хувьчилсан оноо болон үсгэн үнэлгээгээр үнэлнэ.

Хувьчилсан оноо	Үсгээр илэрхийлсэн үнэлгээ
90-100	A
80-89	B
70-79	C
60-69	D
0-59	F

5.6. Техникийн боловсролын төгсөлтийн үнэлгээг дипломын ажлын хамгаалалтаар дүйцүүлж болно.

5.7. Олон улсын хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчийн үнэлгээг тухайн хөтөлбөрийн үнэлгээний арга аргачлалаар үнэлж, үнэлгээний үр дүнгээр боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Зургаа.Үнэлгээ, баталгаажуулалтад оролцогчийн чиг үүрэг

6.1.Үнэлгээнд Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх хэсэгт заасан Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага болон түншлэгч аж ахуйн нэгж байгууллага, сургалтын байгууллага, үнэлгээний ажилтан, баталгаажуулагч, суралцагч, төгсөгч (цаашид “үнэлүүлэгч” гэх) оролцож дараах чиг үүргийн хүрээнд үнэлгээг зохион байгуулна.

6.2.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын чиг үүрэг:

- 6.2.1.үнэлгээний багц төлөвлөгөөний загварыг боловсруулж, батлах;
- 6.2.2.төгсөлтийн үнэлгээний төлөвлөгөө баталгаажуулах;
- 6.2.3.Үнэлгээ, хөндлөнгийн баталгаажуулалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөт үнэлгээний хуваарийг олон нийтэд мэдээлэх;
- 6.2.4.сургалтын байгууллага дээр зохион байгуулагдаж буй төгсөлтийн үнэлгээний тохирц, чанарт хөндлөнгийн баталгаажуулалт хийх;
- 6.2.5.мэргэжлийн холбоод, ажил олгогчийг албан ёсоор төлөөлөх байгууллагатай түншлэлийн гэрээ, санамж бичиг байгуулж хамтран ажиллах;
- 6.2.6.үнэлгээ, баталгаажуулалтын ажилтныг бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, сургалт зохион байгуулах, бүртгэх;
- 6.2.7.үнэлгээний ажилтан, баталгаажуулагчийн хүний нөөцийн чадавхыг холбогдох талуудтай хамтран бэхжүүлэх;
- 6.2.8.үнэлгээг олон улсын арга зүй, аргачлалын дагуу боловсронгуй болгох, судалгаа-шинжилгээ хийх;
- 6.2.9.даалгаврын сан бүрдүүлэх;
- 6.2.10.чадамжийн үнэлгээний цахим системийг хөгжүүлэх, төгсөлтийн үнэлгээнд ашиглах;
- 6.2.11.үнэлгээний ажилтан, баталгаажуулагчийн ёс зүйн дүрмийг батлах;
- 6.2.12.энэхүү журмын 6.2.7-д заасан чиг үүргийг тендер шалгаруулж, төрийн бус байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

6.3.Түншлэгч аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүрэг:

- 6.3.1.даалгаврын сан бүрдүүлэхэд оролцох;
- 6.3.2.чадамжийн нэгжийн болон төгсөлтийн үнэлгээнд оролцох;
- 6.3.3.сургалтын байгууллагад үнэлгээний орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалын нөөц, санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;
- 6.3.4.үйлдвэрлэлийн орчин, ажлын байранд үнэлгээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

6.5.8. үнэлгээний нотлох баримтыг бүрдүүлж, сургалтын албанд хүлээлгэн өгөх;

6.6. Баталгаажуулагчийн чиг үүрэг:

6.6.1. үнэлгээний төлөвлөгөө, зохион байгуулалтын явцыг баталгаажуулах;

6.6.2. үнэлгээний орчинд баталгаажуулалт хийх;

6.6.3. үнэлгээний ажилтанд үнэлгээтэй холбоотой шаардлага тавих, шийдвэрлэх;

6.6.4. үнэлгээний явцад зөрчил гаргасан тохиолдолд анхааруулга өгөх, үнэлгээг зогсоох хүртэл арга хэмжээ авах;

6.6.5. үнэлгээ зохион байгуулагдахаас өмнө үнэлгээний орчин, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материалын хангалтад баталгаажуулалт хийж, шаардлагатай бол үнэлгээг хойшлуулах, зөвлөмж өгөх;

6.6.6. үнэлгээний ажилтан ёс зүйн зөрчил гаргасан, үнэлгээний зарчмыг баримтлаагүй тохиолдолд тухайн үнэлгээний ажилтныг үнэлгээний багаас хасах, үнэлгээг зогсоох, хүчингүй болгох, үнэлгээний ажилтан нь ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн тохиолдолд үнэлгээ хийх эрхийг түдгэлзүүлэх санал хүргүүлэх;

6.7. Үнэлүүлэгчийн чиг үүрэг:

6.7.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон сургалтын байгууллагад хүсэлт гаргаж, чадамжаа үнэлүүлэх;

6.7.2. чадамжийн нэгж, багцаар нотолгоо бүрдүүлэх;

6.7.3. дараах тохиолдолд үнэлгээнээс чөлөөлөгдөнө. Үүнд:

- Олон улсын болон үндэсний мэргэжлийн уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн бол;

- Мэргэжлийн чиглэлээр оюуны өмчийн эрх авсан бол;


6.7.4. суралцагч нь сургалтын төлөвлөгөөний нийт цагийн 40 хувь ба түүнээс дээш цагт хүндэтгэх шалтгаан(өөрөө өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох)-ы улмаас хамрагдаагүй нь нотлогдсон тохиолдолд заавал эзэмших агуулгыг бие даан судалж, үнэлгээнд орох;

6.7.5. үнэлгээний талаар мэдээлэл авах;

6.7.6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулах, мөрдөж ажиллах;

6.7.7. үнэлгээний багц төлөвлөгөөнд тусгагдсан удирдамжийг дагаж мөрдөх;

6.7.8. өөрт болон бусдад хохирол учруулах ёс зүйгүй үйлдэл гаргахгүй байх;

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

6.7.9. үнэлгээний явцад зөвшөөрөгдөөгүй эд зүйлс, багаж, хэрэгсэл ашиглахгүй байх;

6.7.10. үнэлгээний үр дүнгийн талаар Сургалтын албанд гомдлыг бичгээр үнэлгээ зохион байгуулагдсанаас хойш 24 цагийн дотор гаргах гомдол гаргаж, шийдвэрлүүлэх;

6.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т заасны дагуу үнэлгээний ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

Долоо. Үнэлгээг зохион байгуулах арга, хэлбэр

7.1. Үнэлгээний орчин бүрдүүлэх

7.1.1. “MNS6541:2015 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага” стандартад үндэслэн боловсруулсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт заасан орчныг бүрдүүлнэ;

7.1.2. үнэлгээний орчин дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангана;
- Багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн, бүтэн байдлыг шалгаж, үнэлүүлэгчийн тоогоор бэлтгэнэ;
- Чанарын шаардлага хангасан материалыг бэлдэнэ;
- Гадны хүчин зүйл нөлөөлөхгүй байх орчныг бүрдүүлнэ;
- Тусгай нөхцөлийг тодорхой заана /гадаа, өндөрт, хортой, утаатай гэх.мэт/
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч үнэлгээнд оролцох тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон орчин бүрдүүлэх;

7.1.3. явцын ур чадварын үнэлгээнд шаардлагатай материал, багаж, хэрэгслийг хичээл заасан багш бэлтгэж, үнэлгээний орчныг бүрдүүлнэ;


Найм. Нотолгоог бүрдүүлэх аргачлал

8.1. Үнэлгээний багц төлөвлөгөөнд тусгагдсан нотлох баримтыг үнэлгээний үйл явцад бүрэн бүрдүүлнэ.

8.2. Нотлох баримтад үнэлүүлэгчийн нэр, дугаар, үнэлгээ хийгдсэн огноо тодорхой бичигдсэн байхаас гадна үнэлгээний ажилтны мэдээлэл, гарын үсэг зурагдсан, тамга тэмдэг дарагдсан байна.

8.3. Цаашид удаан хугацаанд хадгалах боломжгүй эцсийн бүтээгдэхүүнийг зураг хэлбэрээр үнэлгээний тайлан, нотлох материалд хавсарган хадгална.

8.4. Амьдрах орчноос олж авсан ур чадвараа үнэлүүлэх үнэлүүлэгч нь дараах материалыг бүрдүүлнэ.

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

- 8.4.1 ажил олгогчийн тодорхойлолт, гэрчилгээ, гэрээ хэлцэл;
- 8.4.2 хамтран ажиллагч, үйлчлүүлэгч эсвэл ахлах мэргэжилтэн, ажилтны тайлан мэдээ;
- 8.4.3 ажлын журнал, тэмдэглэл, тайлан эсвэл ажлын баримт бичгийн хэсгийн нотолгоо;
- 8.4.4 сургалтад хамрагдсан нотолгоо;
- 8.4.5 ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, үзэсгэлэнд шалгарсан бүтээлийн жагсаалт;
- 8.4.6 батламж;
- 8.4.7 фото, дүрс бичлэг;
- 8.4.8 чадамжийн нэгж, мэргэшлийн түвшин бүрээр тогтоосон төлбөр төлсөн баримт;

8.5. Үнэлгээнд оролцох боломжгүй хүндэтгэн үзэх шалтгаантай бол нотолгоог хавсарган бичгээр урьдчилан мэдэгдсэн нотолгоо;

Ёс.Хяналт хариуцлага

9.1. Үнэлгээний журам зөрчсөн багш, ажилтанд хөдөлмөрийн гэрээ, сургуулийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулна.

9.2. Суралцагч үнэлгээний журам зөрчсөн тохиолдолд анхааруулга өгөх, шалгалтыг үргэлжлүүлэхгүй зогсоох хүртэл арга хэмжээ авна.

9.3. Албан ёсоор батлуулаагүй материалаар авсан шалгалтыг хүчингүйд тооцно.

9.4. Үнэлгээний явцад үнэлгээний багаас бусад хүн зохих ёсны зөвшөөрөлгүйгээр шалгалт авч буй ангид орох, суралцагчтай харилцах, садаа болох, дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хориглоно.

Арав.Санхүүжилт

10.1. Чадамжид суурилсан сургалтын ур чадварын үнэлгээнд шаардагдах түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог үндэслэн сургалтын байгууллага санхүүжилтийг шийдвэрлэнэ.

10.2. Үнэлгээний багийн гишүүдийн ажлын хөлсийг холбогдох журмыг үндэслэн тухайн сургалтын байгууллага тооцож олгоно.

10.3. Үнэлгээнд хангалтгүй үнэлэгдсэн суралцагчид дахин нэг удаа үнэлгээнд орох эрх олгох бөгөөд хоёр дахь удаагаа дахин үнэлгээнд орох шаардлагатай бол тухайн чадамжийн нэгжид болон тухайн хичээлийн багц цагт ноогдох төлбөрийг сургалтын байгууллагад төлнө.



№ Ж-3-010

Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Арван нэг.Санал гомдол шийдвэрлэх

11.1.Үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд үнэлүүлэгч санал гомдлоо үнэлгээний багт эсвэл сургалтын албанд гаргаж зохих журмын хүрээнд шийдвэрлүүлнэ. Санал гомдлын үндэслэлийг тодорхой бичиж, үнэлгээ хийгдсэн тухайн өдрийн ажлын цагт багтааж өгнө.

11.2.Үнэлгээний баг санал гомдлыг хүлээж аваад шийдвэрлэх арга, хэлбэр, хугацааг 24 цагийн дотор үнэлүүлэгчид тодорхой мэдэгдэнэ.

11.3.Үнэлгээний багийн шийдвэрлэх боломжгүй санал гомдлыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд ажлын 30 хоногт эцэслэн шийдвэрлэнэ.

11.4.Санал гомдлын хариуг заасан хугацаанд багтаан мэдэгдэж, шийдвэрлэх үйл явц нь нээлттэй, ил тод, шударга байна.

Арван хоёр.Бусад

12.1.Иргэн, хуулийн этгээд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн зөвшөөрөлгүйгээр үнэлүүлэгчийн мэдлэг, ур чадварт хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулахыг хориглоно.


12.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөс өөр аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоодоос олгосон чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, дипломыг үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

12.3.Энэхүү журамд тусгагдаагүй зохион байгуулалтын чанартай аливаа асуудлыг сургалтын байгуулга тухай бүр үнэлгээний удирдамжид тусган зохицуулна.

12.4.Иргэн, хуулийн этгээд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх хөндлөнгийн шалгалт зохион байгуулахыг хориглоно.

Арван гурав.Хамаарах баримт бичиг


№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1		Ерөнхий эрдмийн хичээлийн сургалтын чанарыг үнэлэхдээ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалаар батлагдсан "Суралцагчийн чанарын үнэлгээний журам

	№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

2		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/128 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам”
---	--	---

Арван дөрөв.Бүртгэл маягт

№	Бүртгэлийн дугаар	Баримт бичгийн нэр
1	СА-М-7-027	Үнэлгээ баталгаажуулалтын баг томилсон тушаалын хавсралт
2	СА-М-7-028	Үнэлгээний тогтоол
3	СА-М-7-029	Ерөнхий эрдмийн хичээлийн улирлын дүнгийн нэгтгэл
4	СА-М-7-030	Мэргэжлийн хичээлийн улирлын дүнгийн нэгтгэл

 <p>ВМНОГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ</p>	<p>№ Ж-3-010 Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй</p>
--	--	--



№-СА-М-7-027

Оюутан суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар,
чадамжийг үнэлж, баталгаажуулалтын баг томилсон
тушаалын хавсралт маягт

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

1. Үнэлгээ баталгаажуулалтын баг томилсон тушаалын хавсралт

Тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД					
№	Мэргэжлийн нэр	Төгсөх сурагчдын тоо	Үнэлгээний ажилтны нэр	Үүрэг	Утасны дугаар
1				Үнэлгээний багийн ахлагч	
				Гишүүн	
				Гишүүн	
				АО төлөөлөл	
2				Үнэлгээний багийн ахлагч	
				Гишүүн	
				Гишүүн	
				АО төлөөлөл	
3				Үнэлгээний багийн ахлагч	
				Гишүүн	
				Гишүүн	
				АО төлөөлөл	
4				Үнэлгээний багийн ахлагч	
				Гишүүн	
				Гишүүн	
				АО төлөөлөл	
5				Үнэлгээний багийн ахлагч	
				Гишүүн	
				Гишүүн	



№ СА-М-7-028

Үнэлгээний тогтоол

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТООЛ

..... мэргэжлийн ангийн үнэлгээг
2025 оны -р сарын-ны өдөр цагийн хооронд авав.

Хамаарах Чадамжийн нэгжүүд:

Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код

Үнэлгээнд орвол зохих сурагчаас сурагч орж ирц хувь хамрагдсан болно.

Үнэлгээг үнэлүүлэгч бүрээр:

№	Шалгуулагчийн овог нэр	Авбал зохи оноо	Авсан нийт оноо	Хувь	Үнэлгээ	Тайлбар
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
21						
	Ч					
	ХЧЭ					



№ СА-М-7-028

Үнэлгээний тогтоол

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Үнэлгээний багийн ахлагч: /...../
 Үнэлээч: /...../
 Үнэлээч:..... /...../
 Үнэлээч:..... /...../
Баталгаажуулагч:..... /..... /



CA-M-7-030	Баталсан огноо: 2026-01-20
Мэргэжлийн хичээлийн дүнгийн маягт	Хувилбар: V1.2026
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн	Зөвхөн дотоод хэрэгцээнд - Нээлтэй

2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН I УЛИРЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛИЙН ДҮНГИЙН НЭГТГЭЛ

2025.01.02

№	Нэр	Мэргэжлийн суурь		Мэргэшүүлэх хэсэг				ЧАДАМЖТАЙ	СЧХ	Ерөнхий үнэлгээ
		Интрепренершилд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх		Онол		Ур чадвар				
		Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ			
1			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
2			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
3			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
4			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
5			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
6			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
7			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
8			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
9			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
10			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
11			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
12			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
13			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
14			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
15			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
16			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
17			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
18			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
19			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
20			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
21			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
22			ХЧЭ		ХЧЭ		ХЧЭ	0	0	
	4	0		0		0				
	ХЧЭ	0		0		0				0

ХЯНАСАН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Л.ЧИНГЭРЭЛ

АРГА ЗҮЙЧ

Б. АЗЗАЯА

АНГИ УДИРДСАН БАГШ